

БАТЛАВ.  
НИЙСЛЭЛИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ГАЗРЫН  
ДАРГА С.НЯМДОРЖ

2022 оны ... дугаар сарын ...

**НИЙСЛЭЛИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ГАЗРЫН  
АЛБАН ХААГЧДЫН АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН  
БАТАЛГААГ ХАНГАХ 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Улаанбаатар хот

2022.02.14


№	Нийгмийн баталгааг хангах гол үзүүлэлтүүд	Хугацаа	Хариуцах хэлтэс, албан тушаалтан	Хүрэх үр дүн
<b>Нэг: Төрийн албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, үр чадвар, санал санаачилгыг харгалзан цалин хөлс, тэтгэмж урамшууллын уян хатан, ил тод шударга тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр:</b>				
1.1	Албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүнд үндэслэн цалинг нэмэгдүүлэх, бууруулах асуудлыг Засгийн газраас баталсан цалингийн сүлжээнд нийцүүлэн шийдвэрлүүлэх	I улиралд	БТХ	Албан хаагчдын цалингийн шатлал ажлын гүйцэтгэл, үр дүнд нийцсэн байна.
1.2	Төрийн алба хаасан хугацааны, албан тушаалын зэрэг дэвийн, үр чадварын нэмэгдлүүдийг хууль тогтоомжийн хүрээнд олгох асуудлыг шийдвэрлүүлэх	Тухай бүр	БТХ	Төрийн албан хаагч хууль тогтоомжид заасны дагуу цалин хөлс авсан байна.
1.3	Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрийг тохиолдуулан ажлын гүйцэтгэл, үр дүн, сахилга, ёс зүйгээр манлайлан ажилласан албан хаагчийг шагнаан урамшуулах ажлыг зохион байгуулах	Жилдээ	БТХ	Албан хаагчдыг зохих журмын дагуу шагнаан урамшуулсан байна.
1.4	Албан хаагчдын нөхөх төлбөр, буцалтгүй тусламж олгох асуудлыг Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хууль, эрх зүйн актад нийцүүлэн шийдвэрлүүлэх	Тухай бүр	БТХ	Албан хаагчдын хуульд заасан нөхөх төлбөр, тусламж олгогдож,
1.5	Албан үүргээ гүйцэтгэж байх үед нь хүчирхийлэх, заналхийлэх, доромжлох, гүтгэх зэрэг хууль бус үйлдэл гарсан тохиолдолд төрийн албан хаагч, түүний гэр бүлийг хуулийн хүрээнд хамгаалах	Тухай бүр	БТХ	Төрийн албан хаагчийн баталгаа хангагдана.
1.6	Албан хаагчдын үндсэн болон нэмэгдэл, цалин, суутгал, шимтгэлийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг албан хаагчдын албаны цахим хаягаар сар бүр илгээх	Сар бүр	БТХ	Албан хаагчид цалин хөлсөндөө хяналт тавих боломж бүрдэнэ.
<b>Хоёр. Албан хаагчдын ажиллах нөхцөл бололцоог орчин үеийн шаардлагад нийцүүлэн сайжруулах чиглэлээр:</b>				
2.1	Албан хаагчдын тавилга, эд хогшил, техник хэрэгслийг орчин үеийн жишигт нийцүүлэн сайжруулах, ХАБЭА-г хангуулах ажлыг зохион байгуулах	Жилдээ	ССХ	Ажиллах нөхцөл сайжирна.
2.2	Албан хаагчдад өдрийн хоолны болон нийтийн тээврийн унааны	Жилдээ	БТХ	Хуульд заасан хөнгөлөлтийг




	хөнгөлөлт олгох, батлагдсан төсөвтэй уялдуулан нэмэгдүүлэх асуудлыг судлан шийдвэрлүүлэх			эдэлсэн байна.
2.3	Төрийн албан хаагчдад цайны цагаар ашиглах алжаал тайлах, амрах орчин, нөхцөлийг бүрдүүлэх	Жилдээ	БТХ	Албан хаагчдад ээлтэй орчин бүрдсэн байна.
<b>Гурав. Ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл амьдрах дадал хэвшлийг төлөвшүүлэх чиглэлээр:</b>				
3.1	Байгууллагын ажилтан, албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах	IV улиралд	БТХ	Албан хаагч бүр хамрагдсан байна.
3.2	Эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ, эмчилгээ хийлгэх шаардлагатай ажилтнуудад цалинтай, цалингүй чөлөө олгуулах болон бусад хэлбэрээр дэмжлэг үзүүлэх	Тухай бүр	БТХ	Эрүүл мэндийн үйлчилгээ авах боломж бүрдсэн байна.
3.3	Эрүүл мэндийн анхан шатны тусламж үзүүлэх эмийн сан, аппарат хэрэгсэл бүхий цэгийг бий болгох, баяжуулах	Жилдээ	БТХ	Анхны тусламж авах боломж бүрдсэн байна.
3.4	Албан хаагчдын бие бялдрыг чийрэгжүүлэх спортын арга хэмжээ зохион байгуулах, санал, санаачилгыг дэмжин ажиллах	Жилдээ	ССХ	Хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэхэд дэмжлэг үзүүлсэн байна.
<b>Дөрөв. Албан хаагчдын амьдрах нөхцөлийг сайжруулах, гэр бүлийн хөгжлийг дэмжих чиглэлээр:</b>				
4.1	Албан хаагчдын орон сууц, амьдарч буй орчин нөхцөл, нийгмийн асуудлын талаарх судалгаа, мэдээллийн сан бүрдүүлэх	Жилдээ	БТХ	Мэдээллийн сан бүрдсэн байна.
4.2	Албан хаагчдад аливаа төрлийн зээл авахад шаардлагатай баримт, тодорхойлолтыг гаргаж өгөх	Тухай бүр	БТХ	Зээл авахад дэмжлэг үзүүлсэн байна.
4.3	Гэр болон галлагаатай байшинд амьдардаг албан хаагчдад түлээ, нүүрс худалдан авах зардлын дэмжлэг үзүүлэх	IV улиралд	БТХ	Амьдарч буй нөхцөлд дэмжлэг үзүүлсэн байна.
4.4	Хөгжлийн бэрхшээлтэй албан хаагч болон тусгай арчилгаа шаарддаг хүүхэд, өндөр настан асардаг ажилтанд чиглэсэн ажлын цагийн уян хатан бодлогыг хэрэгжүүлэх	Тухай бүр	БТХ	Албан хаагчдад ээлтэй бодлого хэрэгжүүлсэн байна.
4.5	Эцэг эхийн зөвлөл байгуулах, шаардлагатай бол бүрэлдэхүүнийг шинэчлэх, хүүхдэд ээлтэй бодлого, үйл ажиллагааг зохион байгуулан хэрэгжүүлэх	Жилдээ	БТХ	Хүүхдэд ээлтэй бодлого хэрэгжүүлсэн байна.
<b>Тав. Албан хаагчдын сонирхол, хэрэгцээ, сэтгэл зүйн хандлагад нийцүүлж чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хамт олны эвсэг уур амьсгалыг бүрдүүлэх чиглэлээр:</b>				
5.1	Албан хаагчдын харилцаа, хандлагын талаар ганцаарчилсан болон фокус ярилцлага зохион байгуулж, судалгаанд үндэслэн шаардлагатай арга хэмжээг авах, дүгнэлт, шийдвэр гаргуулах	Жилдээ	БТХ	Ажлын байрны дарамтаас урьдчилан сэргийлж, ёс зүйн хэм хэмжээг сахиулсан байна.
5.2	Ахмад болон залуу албан хаагчдын ажлын уялдаа холбоог сайжруулах, байгууллагын залгамж чанарыг хадгалах, багаар ажиллах, туршлага солилцох боломжийг бүрдүүлэх	Жилдээ	БТХ ССХ ХЭХ	Төрийн албаны залгамж чанарыг хадгалах боломж бүрдсэн байна.



5.3	Баяр ёслол, амралтын өдрүүдийг хамт олноороо тэмдэглэн өнгөрүүлэх, аялал зугаалга, урлагийн арга хэмжээ зохион байгуулж, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх нөхцөлийг бүрдүүлэх	Жилдээ	БТХ ССХ ХЭХ	Хамт олныг идэвхжүүлсэн байна.
-----	--	--------	-------------------	--------------------------------

ХЯНАСАН:  
БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН  
ДАРГА  Г.ГАНТУШИГ

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:  
ХҮНИЙ НӨӨЦ, ГЭРЭЭ, ЭРХ ЗҮЙ ХАРИУЦСАН  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН  Д.БАЯСГАЛАН